

**ДЭЭД БОЛОВСРОЛД ХАМААРАХ ЭРДМИЙН ЗЭРГИЙГ  
ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ  
ДЭЛХИЙ ДАХИНЫ КОНВЕНЦ**

**Оршил**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хурлын дөчдүгээр чуулган 2019 оны 11 дүгээр сарын 12-ноос 27-ны өдрүүдэд Парис хотноо хуралдаж,

Оролцогч улсуудын хооронд боловсрол, газар зүй, хүмүүнлэг, соёл, шинжлэх ухаан, нийгэм-эдийн засгийн харилцаа холбоог бэхжүүлэх, бүс нутаг хоорондын яриа хэлэлцээ болон тэдгээрийн харилцан хүлээн зөвшөөрөх баримт бичиг, үйл ажиллагааг өргөжүүлэх нийтлэг хүсэл сонирхолд **хөтлөгдөн,**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын Дүрэмд "тус Байгууллагын зорилго нь боловсрол, шинжлэх ухаан, соёлоор дамжуулан улс үндэстнүүдийн хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар энх тайван, аюулгүй байдалд хувь нэмэр оруулахад оршино" гэснийг **санаж,**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм (1945), Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948), Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц (1951) ба түүний протокол (1967), Харьяалалгүй этгээдийн эрх зүйн байдлын тухай конвенц (1954), Боловсролын талаар алагчилахын эсрэг ЮНЕСКО-гийн конвенц (1960), ялангуяа түүний 4а дүгээр зүйл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966), Техник болон мэргэжлийн боловсролын тухай ЮНЕСКО-гийн конвенц (1989)-ийн заалтуудыг **харгалзан,**

Дээд боловсролын сургалт, эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай ЮНЕСКО-гийн зөвлөмж (1993), Дээд боловсролын багшлах боловсон хүчний эрх зүйн байдлын тухай ЮНЕСКО-гийн зөвлөмж (1997), Уугуул иргэдийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын тунхаглал (2007), Шинжлэх ухаан ба шинжлэх ухааны ажилтнуудын тухай ЮНЕСКО-гийн зөвлөмж (2017)-ийг **харгалзан,**

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай ЮНЕСКО-гийн бүс нутгийн конвенцуудад **тулгуурлан,**

Бүх түвшинд чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй олгохыг болон насан туршдаа суралцах бололцосг бүх нийтэд олгохыг дэмжих Оролцогч улсуудын үүрэг хариуцлагыг **дахин нотолж,**

Дээд боловсролын салбар дахь өргөжин тэлж байгаа олон улсын хамтын ажиллагаа, оюутан, ажилтан, мэргэжилтэн, судлаач, эрдэмтдийн шилжилт хөдөлгөөн, шинжлэх ухааны судалгаанд гарч байгаа өөрчлөлт, багшлах болон суралцахад нэвтэрч байгаа төрөл бүрийн арга, хэлбэр, дэвшил, инновацыг **ойлгон ухамсарлаж,**



Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын олгож байгаа дээд боловсрол нь нийтийн сайн сайхны төлөө бөгөөд бүх нийтийн үүрэг хариуцлага болохыг **харгалзаж**, мөн түүнчлэн эрдэм шинжилгээ, судалгааны эрх чөлөөний зарчим болон дээд боловсролын байгууллагын бие даасан хараат бус байх зарчмыг **дэмжиж, хамгаалах хэрэгцээ шаардлагыг ойлгож**,

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг олон улсад хүлээн зөвшөөрөх нь суралцагсад болон сурах арга барил, эрдэм шинжилгээ, шинжлэх ухааны судалгаа, судлаач, ажилтан, мэргэжилтний шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан харилцан суралцах болон мэдлэгийг хамтран хөгжүүлэх үйл явцыг бий болгож, дээд боловсролын салбарт олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ гэдэгт **итгэж**,

Оролцогч улсуудын соёлын ялгаатай байдал, тэр дундаа боловсрол олгох уламжлал болон дээд боловсролын үнэлэмжийн ялгаатай талуудыг **хүндэтгэн**,

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай ЮНЕСКО-гийн бүс нутгийн конвенцуудад нэмэлт болгох, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах үүднээс дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц гаргах хэрэгцээ шаардлагыг хангахыг **хүсч**,

Эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг дэлхий даяар сайжруулах нийтлэг, амьдралд хэрэгжихүйц, ил тод шийдэл олох хэрэгцээ байгаад **итгэж**,

Энэхүү Конвенц нь дэлхий дахины эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх, чанарыг баталгаажуулах, эрдэм шинжилгээний онолын нэгдмэл байдалтай холбоотой шударга, ил тод журмын талаар олон улсын шилжилт хөдөлгөөн, мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ гэдэгт **итгэж**,

Энэхүү Конвенцыг 2019 оны арван нэгдүгээр сарын хорин тавны энэ өдөр **батлав**.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

### I зүйл

Энэхүү Конвенцод доорх нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

**Боломж (дээд боловсрол эзэмших)** гэж шалгуур хангасан аливаа хувь хүн дээд боловсрол эзэмшихээр хүсэлт гаргах, элсэлтийн шалгалтад оролцох эрхийг,

**Элсэлт (дээд боловсролын байгууллага ба хөтөлбөрийн)** гэж тухайн байгууллага ба/эсхүл хөтөлбөрт дээд боловсрол эзэмших боломжийг шалгуур хангасан өргөдөл гаргагчид олгож буй үйл ажиллагаа буюу тогтолцоог,

**Өргөдөл гаргагч** гэж

(а) хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллагад өөрийн эрдмийн зэрэг, хэсэгчилсэн сургалт, эсхүл өмнөх сургалтыг үнэлүүлэх ба/эсхүл хүлээн зөвшөөрүүлэхээр өргөдөл гаргаж буй хувь хүнийг,



(b) хувь хүнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр тухайн хувь хүний нэрийн өмнөөс өргөдөл гаргаж буй байгууллагыг,

**Үнэлгээ** гэж эрдмийн зэргийн үнэлгээний үйл явцад оролцдог хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллагаас өргөдөл гаргагчийн эрдмийн зэрэг, хэсэгчилсэн сургалт, өмнөх сургалтыг үнэлсэн үнэлгээг,

**Эрх бүхий байгууллага** гэж тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх эрх мэдэл, чадавх, эрх зүйн чадамжтай хувь хүн, эсхүл байгууллагыг,

**Хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллага** гэж Оролцогч улсын хууль, дүрэм журам, бодлого, эсхүл тогтсон дадлын дагуу эрдмийн зэргийг үнэлэх, эсхүл хүлээн зөвшөөрөх талаар шийдвэр гаргах байгууллагыг,

**Засаг захиргааны нэгж** гэж энэхүү Конвенцын ХХ зүйлийн (b) хэсгийн дагуу холбооны эсхүл нэгдмэл бус үндсэн хуулийн тогтолцоо ёсоор Конвенцын Оролцогч улсын аймаг, муж, тойрог, дүүрэг зэрэг орон нутгийн засаг захиргааны түвшин дэх албан ёсны байгууллагыг,

**Хил дамнасан боловсрол** гэж иргэд, мэдлэг, хөтөлбөр, боловсролын байгууллага, сургалтын хөтөлбөрийн Оролцогч улсуудын хил дамнасан хөдөлгөөнийг хамарсан боловсрол олгох бүхий л хэлбэрийг хэлэх бөгөөд үүнд олон улсын хамтарсан зэрэг олгох чанарын баталгаа бүхий хөтөлбөр, хил дамнасан дээд боловсрол, үндэстэн дамнасан боловсрол, оффшор боловсрол, хил хязгааргүй боловсролыг оруулах боловч эдгээрээр хязгаарлахгүй,

**Шилжин суурьшсан этгээд** гэж оршин суудаг орон нутаг, орчин, ажил мэргэжлийн үйл ажиллагаанаасаа аргагүй нөхцөл байдлын улмаас өөр нутаг орон, орчинд шилжин суурьшсан хувь хүнийг,

**Албан ёсны боловсролын тогтолцоо** гэж Оролцогч улсын боловсролын тогтолцоог, түүний дотор боловсрол олгох үүрэг бүхий албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн бүх байгууллага, түүнчлэн Оролцогч улсын эрх бүхий байгууллагуудаас сургалт болон боловсролтой холбоотой бусад үйлчилгээг үзүүлэхээр хүлээн зөвшөөрөгдөж, эрх олгогдсон төрийн болон хувийн хэвшлийн боловсролын бүх түвшний байгууллагыг,

**Албан ёсны сургалт** гэж зохион байгуулалттай сургалтын тогтолцоогоор албан ёсны зэрэг олгоход чиглэсэн үйл ажиллагааны дагуу хэрэгждэг, сургалтын үйл ажиллагааг явуулахаар Оролцогч улсын эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдөж, түүгээр эрх олгогдсон боловсролын байгууллагаас олгох сургалтыг,

**Дээд боловсрол** гэж Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд дээд боловсролын тогтолцоонд нь хамаарах бүрэн дунд боловсролын дараах шатны бүх төрлийн сургалтын хөтөлбөр, эсхүл багц хөтөлбөрийг,



**Дээд боловсролын байгууллага** гэж дээд боловсрол олгодог, Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд дээд боловсролын тогтолцоонд нь хамаарах байгууллагыг,

**Дээд боловсролын хөтөлбөр** гэж Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд дээд боловсролын тогтолцоонд нь хамаардаг, төгсөгчдөдөө дээд боловсролын эрдмийн зэрэг олгодог, бүрэн дунд боловсролын дараах сургалтын хөтөлбөрийг,

**Албан бус сургалт** гэж албан ёсны сургалтаас гадуур, ажил, гэр бүл, орчин эсхүл чөлөөт цагтай холбоотой өдөр тутмын үйл ажиллагааны үр дүнд бий болох суралцах үйл явцыг,

**Олон улсын хамтарсан зэрэг** гэж хил дамнасан боловсролын зэргийн төрөл бөгөөд нэгээс дээш улсад хамаарах хоёр буюу түүнээс дээш дээд боловсролын байгууллагаас олгодог нэгтгэн уялдуулсан, хамтарсан хөтөлбөрийг дүүргэснийг хүлээн зөвшөөрч болон/буюу зөвшөөрч, хамтран олгож буй эрдмийн нэг зэргийг,

**Сургалтын үр дүн** гэж суралцагчийн суралцах үйл явцыг дуусгасны эцэст олж авсан мэдлэг, чадварыг,

**Насан туршийн сургалт** гэж амьдралын мөчлөгийг бүхэлд нь хамарсан, хувь хүний чадавх, мэдлэг, ур чадвар, хандлага, чадамжийг сайжруулж, хөгжүүлэхэд чиглэсэн албан ёсны, албан ёсны бус, албан бус бүхий л суралцах үйл ажиллагааг багтаасан үйл явцыг,

**Шилжилт хөдөлгөөн** гэж хувь хүмүүс эх орноосоо гадна сурах, судалгаа хийх, багшлах, эсхүл ажиллах зорилгоор биечлэн эсхүл цахимаар хийх хөдөлгөөнийг,

**Албан ёсны бус сургалт** гэж албан ёсны боловсролын тогтолцоонд хамаардаггүй бөгөөд ажиллаж, амьдрахад анхаардаг боловсрол, сургалтын хүрээнд олж авах мэдлэгийг,

**Сургалтын уламжлалт бус арга** гэж боловсролын хөтөлбөр болон сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ сурган хүмүүжүүлэгч болон суралцагсдыг нүүр тулан харилцахад голлон анхаарал хандуулдаггүй албан ёсны, албан ёсны бус, эсхүл албан бус сургалтын арга ажиллагааг,

**Хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх** гэж бүрэн гүйцэд дүүргэсэн эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллагаас үлэмж ялгаатай гэдэг үндэслэлээр бүрэн хүлээн зөвшөөрөх боломжгүй нөхцөлд хэсэгчлэн хүлээн зөвшөөрөхийг,

**Хэсэгчилсэн сургалт** гэж бүрэн хэмжээний хөтөлбөр биш хэдий ч үлэмж мэдлэг, чадвар, хандлага, чадамж олгож чадахуйц, үнэлгээнд хамрагдсан дээд боловсролын хөтөлбөрийн аль нэг хэсгийг,

**Өмнөх сургалт** гэж хувь хүний албан ёсны, албан ёсны бус, эсхүл албан бус сургалтын үр дүнд олж авсан, тухайн сургалтын үр дүн, зорилго эсхүл стандартын хувьд үнэлж дүгнэсэн туршлага, мэдлэг, ур чадвар, хандлага, чадамжийг,



## Эрдмийн зэрэг:

(а) **Дээд боловсролын эрдмийн зэрэг** гэж дээд боловсролын хөтөлбөрийг амжилттай дүүргэснийг гэрчилсэн, эсхүл өмнөх сургалтыг баталгаажуулсан (аль холбогдох) эрх бүхий байгууллагаас олгосон аливаа зэрэг, диплом, гэрчилгээ, эсхүл шийдвэрийг,

(б) **Дээд боловсрол эзэмших эрх олгох эрдмийн зэрэг** гэж боловсролын хөтөлбөрийг амжилттай дүүргэснийг гэрчилсэн, эсхүл өмнөх сургалтыг баталгаажуулсан (аль холбогдох), тухайн зэргийг эзэмшигч этгээдэд дээд боловсролын байгууллагын элсэлтийн шалгалтад орох эрх олгож байгаа эрх бүхий байгууллагаас олгосон аливаа зэрэг, диплом, гэрчилгээ, эсхүл шийдвэрийг,

**Шаардлага хангасан өргөдөл гаргагч** гэж холбогдох шалгуурыг хангаж, дээд боловсролын сургалтын элсэлтийн шалгалтад оролцох эрхтэй гэж тооцогдсон хувь хүнийг,

**Эрдмийн зэргийн хүрээ** гэж тогтоосон шалгуурын дагуу чанарын баталгаа бүхий эрдмийн зэрэг/мэргэжлийн ангилал, нийтлэл, зохион байгуулалтын тогтолцоог,

**Чанарын баталгаажуулалт** гэж боловсролын хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг тасралтгүй мөрдөж, сайжруулж байгаагаа холбогдох талуудад баталгаажуулах зорилгоор дээд боловсролын тогтолцоо, байгууллага, эсхүл хөтөлбөрийн чанарт эрх бүхий байгууллагаас үнэлгээ хийх тасралтгүй үйл явцыг,

**Хүлээн зөвшөөрөх** гэж өргөдөл гаргагчийн гадаад улсад эзэмшсэн боловсролын эрдмийн зэрэг, хэсэгчилсэн сургалт, өмнөх сургалтын хүчин төгөлдөр байдал болон эрдмийн түвшинг эрх бүхий байгууллагаас дараах зорилгоор (гэхдээ эдгээрээр хязгаарлахгүй) албан ёсоор хүлээн зөвшөөрөхийг:

(а) дээд боловсролын элсэлтийн шалгалтад орох эрх олгох; ба/эсхүл

(б) ажил хөдөлмөрийн боломжийг эрэлхийлэх бололцоо олгох,

**Бүс нутаг** гэж ЮНЕСКО-гийн үйл ажиллагааг бүс нутгийн түвшинд хэрэгжүүлэх зорилгоор ЮНЕСКО-гийн бүс нутгийн тодорхойлолтын дагуу тогтоосон, тухайлбал, Африк, Арабын улсууд, Ази болон Номхон далай, Европ, Латин Америк ба Карибын аль нэг бүсийг,

**Хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенц** гэж ЮНЕСКО-гийн бүс нутаг тус бүрт дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай ЮНЕСКО-гийн конвенцууд, түүний дотор Газрын дундад тэнгисээр хиллэдэг Араб болон Европын улсуудад дээд боловсролын сургалт, диплом, эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай конвенцыг,

## Тавигдах шаардлага:



(a) **Ерөнхий шаардлага** гэж дээд боловсролын тодорхой хөтөлбөр эсхүл түүний аль нэг түвшинд элсэх, эсхүл дээд боловсролын эрдмийн зэргийг тухайн түвшинд авахын тулд хангавал зохих болзол нөхцөлийг,

(b) **Тусгай шаардлага** гэж ерөнхий шаардлагаас гадна дээд боловсролын тодорхой хөтөлбөрт элсэх, эсхүл тодорхой салбарт дээд боловсролын тусгайлсан эрдмийн зэрэг авахад хангавал зохих болзол нөхцөлийг,

**Үлэмж ялгаа** гэж өргөдөл гаргагч хүссэн үйл ажиллагаа явуулах, тухайлбал, үргэлжлүүлэн суралцах, судалгаа хийх, хөдөлмөр эрхлэх (гэхдээ эдгээрээр хязгаарлахгүй)-эд саад болж болзошгүй гадаад улсын эрдмийн зэрэг болон тухайн Оролцогч улсын эрдмийн зэрэг хоорондын томоохон ялгааг тус тус хэлнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. КОНВЕНЦЫН ЗОРИЛГО

### II зүйл

Хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцуудад тулгуурлан, тэдгээрийн уялдаа холбоо, нэмэлт өөрчлөлт, ололт амжилтыг бэхжүүлэх үүднээс энэхүү Конвенц нь дараах зорилготой байна. Үүнд:

1. Дээд боловсролын чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, бэхжүүлэх;
2. Дээд боловсролын чиглэлээрх олон улсын хамтын ажиллагааны зорилгоор бүс нутаг хоорондын санал санаачилга, бодлого, инновацыг дэмжих;
3. Энэхүү Конвенцын Оролцогч улсуудын дээд боловсролын тогтолцооны ялгаатай байдлыг ойлгож, хүндлэхийн зэрэгцээ Оролцогч улсуудын дээд боловсролын эрдмийн зэрэг эзэмшигчид, дээд боловсролын байгууллагууд, ажил олгогчид, бусад оролцогч талд харилцан ашигтай байлгах үүднээс дэлхий дахинд дээд боловсролын салбар дахь шилжилт хөдөлгөөн болон ололт амжилтыг хөнгөвчлөн дэмжих;
4. Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг шударга, ил тод, тууштай, уялдаатай, цаг үеэ олсон, найдвартайгаар хүлээн зөвшөөрөх зорилгоор дэлхий нийтийг хамарсан хүртээмжтэй тогтолцоог бий болгох;
5. Дээд боловсролын байгууллага болон тогтолцооны бие даасан бөгөөд ялгаатай байдлыг хүндэтгэж, дэмжиж, хамгаалах;
6. Шударга байдал, ёс зүйн хэм хэмжээг *inter alia* хөхиүлэн дэмжих замаар эрдмийн зэргийн чанар, найдвартай байдалд итгэх итгэл, үнэмшлийг дээшлүүлэх;
7. Олон улсын шилжилт хөдөлгөөнийг дэмжих зорилгоор эрдмийн зэргийн хүрээнд болон эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөхөд дээд боловсролын байгууллага, тогтолцоонд чанарын баталгаажуулалтын соёлыг хөхиүлэн дэмжиж, чанарын баталгаажуулалт найдвартай, уялдаа холбоотой, харилцан нөхөхүйц байхад шаардлагатай чадавхыг хөгжүүлэх;



8. Холбогдох тал, Оролцогч улсууд, бүс нутгийн хооронд хүртээмжтэй, орчин үеийн, найдвартай, ил тод, холбогдол бүхий мэдээлэл боловсруулах, цуглуулах, солилцох, мөн шилдэг туршлагыг түгээх үйл явцыг хөхиүлэн дэмжих;

9. Чанартай дээд боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших боломжийг эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх замаар хөхиүлэн дэмжих, дүрвэгсэд ба шилжин суурьшсан этгээдийг оролцуулан бүх хүнд насан туршийн сургалтын боломжийг бүрдүүлэн дэмжих;

10. Тогтвортой хөгжлийн төлөө боловсролыг дэмжих үүднээс хүний нөөц болон боловсролын нөөцийг оновчтой ашиглахыг дэлхий даяар хөхиүлэн дэмжиж, бүх орны зохион байгуулалтын бүтэц, эдийн засаг, технологи, соёл, ардчилал, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зэрэг болно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ДЭЭД БОЛОВСРОЛД ХАМААРАХ ЭРДМИЙН ЗЭРГИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ҮНДСЭН ЗАРЧИМ

### III зүйл

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх зорилгоор энэхүү Конвенцоор дараах зарчмыг тогтоов. Үүнд:

1. Дээд боловсрол эзэмших өргөдөл гаргах, эсхүл ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор хувь хүмүүс өөрсдийн боловсролын зэрэгт үнэлгээ хийлгэх эрхтэй.

2. Эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх үйл явц нь Оролцогч улс бүрийн дүрэм, журмын дагуу ил тод, шударга, цаг үеэ олсон, алагчлалаас ангид байхаас гадна хямд өртөгтэй байна.

3. Хүлээн зөвшөөрөх тухай шийдвэр нь итгэлцэл, тодорхой шалгуур болон шударга, ил тод, алагчлалаас ангид журамд үндэслэсэн бөгөөд дээд боловсролын тэгш хүртээмжтэй байдал бол хөдөлмөр эрхлэх боломжийг нээсэн нийтийн сайн сайхны төлөө үйл хэрэг мөн болохын чухлыг онцолно.

4. Хүлээн зөвшөөрөх тухай шийдвэр нь дээд боловсролын тогтолцоо, байгууллага, хөтөлбөр, чанарын баталгаа олгох механизмын талаарх зохистой, найдвартай, хүртээмжтэй, орчин үеийн мэдээлэлд үндэслэх бөгөөд эдгээр мэдээллийг Оролцогч улсуудын эрх бүхий байгууллага, үндэсний албан ёсны мэдээллийн төв, эсхүл тэдгээртэй ижил төстэй байгууллагаас хүлээн авсан байна.

5. Хүлээн зөвшөөрөх тухай шийдвэрийг дэлхий дахины дээд боловсролын тогтолцооны ялгаатай байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр гаргасан байвал зохино.

6. Хүлээн зөвшөөрөх үнэлгээ хийх эрх бүхий байгууллага шийдвэрийг чин шударгаар гаргаж, шийдвэрийнхээ үндэслэлийг тодорхой тайлбарлах бөгөөд уг шийдвэрт гомдол гаргах журмыг тогтоосон байна.



7. Эрдмийн зэргээ хүлээн зөвшөөрүүлэхээр өргөдөл гаргагч нь эзэмшсэн эрдмийн зэргийнхээ талаар зохих ёсны, үнэн зөв мэдээлэл, бичиг баримтыг шударгаар бүрдүүлж өгөх бөгөөд холбогдох шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй байна.

8. Оролцогч улсуудын хооронд орчин үеийн технологи болон мэдээлэл солилцох сүлжээг ашиглахыг урамшуулан дэмжих замаар Оролцогч улсууд дээд боловсролын эрдмийн зэрэгтэй холбоотой бүх хэлбэрийн хууран мэхлэх үйлдлийг устгах арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. КОНВЕНЦЫН ОРОЛЦОГЧ УЛСЫН ҮҮРЭГ**

Энэхүү конвенцоор Оролцогч улсууд дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

### **IV зүйл. Дээд боловсрол эзэмших боломж олгох эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх**

1. Тухайн эрдмийн зэргийг олгосон Оролцогч улсын дээд боловсрол эзэмших эрх олгох ерөнхий шаардлага болон уг эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын ерөнхий шаардлагын хооронд үлэмж ялгаа байхгүй тохиолдолд эдгээр Оролцогч улсын дээд боловсрол эзэмших эрх олгох ерөнхий шаардлагыг хангасны үндсэн дээр Оролцогч улс бүр өөрийн улсын дээд боловсролын тогтолцоонд хамруулах зорилгоор бусад Оролцогч улсад эзэмшсэн эрдмийн зэрэг болон баримтжуулсан эсхүл гэрчлүүлсэн өмнөх сургалтыг хүлээн зөвшөөрнө. Аль эсхүл, нэг Оролцогч улсад эрдмийн зэрэг олж авсан нь нөгөө Оролцогч улсад тухайн эрдмийн зэргийн үнэлгээ хийлгэхэд хангалттай.

2. Хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын уламжлалт бус аргаар олж авсан эрдмийн зэргийг чанарын баталгаажуулалтын харьцуулах боломжтой механизмд хамруулах бол тухайн Оролцогч улс буюу түүний засаг захиргааны нэгжийн дүрэм, журмын дагуу үнэлгээ хийх бөгөөд үнэлгээнд сургалтын уламжлалт аргаар олж авсан ижил төстэй эрдмийн зэрэгт хэрэглэдэг шалгуурыг ашиглана.

3. Тухайн эрдмийн зэрэг нь эрдмийн зэрэг олгосон Оролцогч улсын дээд боловсролын зөвхөн тодорхой төрлийн байгууллага эсхүл хөтөлбөрт хамрагдах боломж олгож буй бол Оролцогч улс бүр үлэмж ялгаа байхгүй бөгөөд боломжтой нөхцөлд өөрийн дээд боловсролын тогтолцоон дахь ижил төрлийн дээд боловсролын байгууллагад суралцах эсхүл хөтөлбөрт хамрагдах боломжийг тухайн эрдмийн зэрэг эзэмшигчид олгоно.

### **V зүйл. Дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх**

1. Хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт гаргасан эрдмийн зэрэг болон түүнийг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын ижил төрлийн эрдмийн зэргийн хооронд үлэмж ялгаа байхгүй тохиолдолд Оролцогч улс бүр бусад Оролцогч улсад олгосон дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрнө. Аль эсхүл, нэг Оролцогч улсад дээд боловсролын эрдмийн зэрэг олж авсан нь нөгөө Оролцогч улсад тухайн эрдмийн зэргийн үнэлгээг уг эрдмийн зэргийг эзэмшигчийн хүсэлтээр хийлгэхэд хангалттай.

Гарын үсэг /Signature: *П. Гундвант*.....  
2023 оны 01 сарын 10 өдөр  
Улаанбаатар хот  
Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION



2. Чанарын баталгаажуулалтын харьцуулах боломжтой механизмд хамаарах бөгөөд аль нэг Оролцогч улсын дээд боловсролын тогтолцооны нэг хэсэг хэмээн тооцогдох сургалтын уламжлалт бус хүлээн зөвшөөрөгдсөн аргаар олж авсан эрдмийн зэргийн үнэлгээг тухайн хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн дүрэм, журмын дагуу, сургалтын уламжлалт аргаар олж авсан ижил төстэй эрдмийн зэрэгт хэрэглэдэг шалгуурыг ашиглан хийнэ.

3. Олон улсын хамтарсан эрдмийн зэрэг олгодог хил дамнасан боловсролын хүрээнд олж авсан, эсхүл наад зах нь нэг улс нь энэхүү Конвенцын Оролцогч улс болох нэгээс дээш улсад хэрэгжүүлсэн хамтарсан аливаа бусад хөтөлбөрийн хүрээнд олж авсан дээд боловсролын эрдмийн зэргийн үнэлгээг тухайн хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн дүрэм, журмын дагуу, нэг улсад хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд олж авсан эрдмийн зэрэгт хэрэглэдэг шалгуурыг ашиглан хийнэ.

4. Өөр Оролцогч улсад олгосон дээд боловсролын эрдмийн зэргийг аливаа Оролцогч улс хүлээн зөвшөөрснөөр дор дурдсан үр дүнгийн наад зах нь нэг нь гарна. Үүнд:

(a) тухайн эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсад дээд боловсролын эрдмийн зэрэг эзэмшигчдэдээ олгодогтой адил нөхцөлөөр дээд боловсролоо үргэлжлүүлэхээр элсэлтийн шалгалт өгөх эрхийг уг эрдмийн зэргийг эзэмшигчид олгоно; болон/эсхүл

(b) тухайн эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн хууль тогтоомж, эсхүл дүрэм журмын дагуу дээд боловсролын эрдмийн зэргийн цолыг ашиглах эрхийг уг эрдмийн зэргийг эзэмшигчид олгоно.

Түүнчлэн, үнэлгээ хийж, хүлээн зөвшөөрснөөр эрдмийн зэрэг бүхий өргөдөл гаргагчдад тухайн эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн хууль тогтоомж, эсхүл дүрэм журмын дагуу хөдөлмөр эрхлэлтийн боломж хайхад дэмжлэг болж болно.

5. Хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт гаргагдсан эрдмийн зэрэг болон хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын ижил төрлийн эрдмийн зэргийн хооронд үлэмж ялгаа байгааг нотолж чадах тохиолдолд хүлээн зөвшөөрөх эрх бүхий тухайн байгууллага уг эрдмийн зэргийг хэсэгчлэн хүлээн зөвшөөрч болох эсэхийг тогтоохыг оролдоно.

6. Оролцогч улс бүр хил дамнасан боловсролын хөтөлбөрийн хүрээнд олж авсан эсхүл тухайн Оролцогч улсын харьяалалд үйл ажиллагаа явуулж буй гадаадын боловсролын байгууллагаас олгосон дээд боловсролын эрдмийн зэргийг тухайн Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн хууль тогтоомж буюу дүрэм журмын тодорхой шаардлагыг мөрдөх эсхүл тухайн боловсролын байгууллагыг үүсгэн байгуулсан Оролцогч улстай байгуулсан тодорхой хэлэлцээрийг мөрдөх нөхцлөөр хүлээн зөвшөөрч болно.

МОНГОЛ УЛСЫН ГАРЫН ҮСЭГ  
Гарын үсэг (Signature): *P. Guberg*  
2023 оны 01 сарын 16 өдөр  
Улаанбаатар хот  
Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

## VI зүйл. Хэсэгчилсэн сургалт болон өмнөх сургалтыг хүлээн зөвшөөрөх

1. Хэсэгчилсэн сургалт эсхүл өмнөх сургалт ба хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээн авсан Оролцогч улсын дээд боловсролын хөтөлбөрт тухайн хэсэгчилсэн эсхүл өмнөх сургалтын орлох тэр хэсгийн хооронд үлэмж ялгаа байхгүй тохиолдолд Оролцогч улс бүр өөр Оролцогч улсад олж авсан баримтжуулсан буюу гэрчлүүлсэн хэсэгчилсэн сургалт эсхүл баримтжуулсан буюу гэрчлүүлсэн өмнөх сургалтыг Оролцогч улсуудын боловсрол эзэмших боломжтой холбоотой хууль тогтоомжийг харгалзан үзэж дээд боловсролын хөтөлбөрийг дүүргэх эсхүл дээд боловсролын сургалтыг үргэлжлүүлэх зорилгоор аль зохих тохиолдолд хүлээн зөвшөөрч болно. Аль эсхүл, энэ нь өөр Оролцогч улсад баримтжуулсан буюу гэрчлүүлсэн хэсэгчилсэн сургалтад эсхүл баримтжуулсан буюу гэрчлүүлсэн өмнөх сургалтад хамрагдсан хувь хүний хувьд түүний хүсэлтийг үндэслэн уг хэсэгчилсэн сургалт эсхүл өмнөх сургалтын үнэлгээг Оролцогч улс хийхэд хангалттай байна.

2. Чанарын баталгаажуулалтын харьцуулах боломжтой механизмд хамаарах бөгөөд аль нэг Оролцогч улсын дээд боловсролын тогтолцооны нэг хэсэг хэмээн тооцогдох сургалтын уламжлалт бус хүлээн зөвшөөрөгдсөн аргаар олгосон дээд боловсролын хөтөлбөрийг хэсэгчлэн дүүргэснийг баримтжуулсан буюу гэрчлүүлсний үнэлгээг тухайн Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн дүрэм, журмын дагуу, сургалтын уламжлалт аргаар олгосон хэсэгчилсэн сургалтад хэрэглэдэг шалгуурыг ашиглан хийнэ.

3. Олон улсын хамтарсан эрдмийн зэрэг олгодог хил дамнасан боловсролын хүрээнд олж авсан, эсхүл наад зах нь нэг улс нь энэхүү Конвенцын Оролцогч улс болох нэгээс дээш улсад хэрэгжүүлсэн хамтарсан аливаа бусад хөтөлбөрийн хүрээнд олж авсан дээд боловсролын хөтөлбөрийг хэсэгчлэн дүүргэснийг баримтжуулсан буюу гэрчлүүлсний үнэлгээг тухайн Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн дүрэм, журмын дагуу, нэг улсад олж авсан хэсэгчилсэн сургалтад хэрэглэдэг шалгуурыг ашиглан хийнэ.

## VII зүйл. Дүрвэгсэд ба шилжин суурьшсан этгээдийн хамрагдсан хэсэгчилсэн сургалт ба эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх

Дүрвэгсэд ба шилжин суурьшсан этгээд дээд боловсролд хамрагдах, дээд боловсролын хөтөлбөрийг үргэлжлүүлэх, эсхүл ажил хөдөлмөр эрхлэх боломж хайхад тавигдах зохих шаардлагыг хангасан эсэхийг шударгаар, үр дүнтэй үнэлэх оновчтой журам боловсруулах талаар Оролцогч улс бүр боловсролын тогтолцооныхоо хүрээнд үндсэн хууль, хууль тогтоомж болон зохицуулалтын заалтдаа нийцүүлэн шаардлагатай, хэрэгжихүйц арга хэмжээг авах бөгөөд үүнд бусад улсад олж авсан хэсэгчилсэн сургалт, өмнөх сургалт буюу эрдмийн зэргийг нотлох баримтаар нотолж чадахгүй байгаа тохиолдлыг багтаана.

## VIII зүйл. Үнэлгээ хийхэд болон хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай мэдээлэл

1. Оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ олгодог эрдмийн зэрэг болон сургалтын үр дүнг бүрэн гүйцэд тодорхойлох боломжтой ил тод тогтолцоог бүрдүүлнэ.

2. Оролцогч улс бүр дээд боловсролын тогтолцоонд нь итгэх итгэл, үнэмшилгүйг нэмэгдүүлэх үүднээс дээд боловсролын байгууллагууддаа зөвшөөрөл олгох,

2023 оны 01 сарын 10 өдөр  
Улаанбаатар хот

хүлээн зөвшөөрөх, чанарын баталгаа олгох бодитой, найдвартай тогтолцоог үндсэн хууль, хууль тогтоомж болон зохицуулалтын байдал, бүтэцдээ тулгуурлан боломжит хэмжээнд бүрдүүлнэ.

3. Оролцогч улс бүр дээд боловсролын тогтолцооныхоо тухай холбогдох, үнэн зөв, цаг үеийн мэдээллийг хүртээмжтэй байлгах үүднээс үндэсний мэдээллийн төв эсхүл түүнтэй төстэй бүтцийг байгуулж, ажиллуулна.

4. Оролцогч улс бүр мэдээллийг хялбараар авах боломжийг хангах үүднээс технологи ашиглахыг хөхиүлэн дэмжинэ.

5. Оролцогч улс бүр:

(a) Зохих тохиолдолд дээд боловсролын тогтолцоо, эрдмийн зэрэг, чанарын баталгаажуулалт, эрдмийн зэргийн цар хүрээнийхээ талаар албан ёсны, үнэн зөв мэдээлэл авах боломжоор хангана;

(b) Бусад Оролцогч улсын дээд боловсролын тогтолцоо, эрдмийн зэрэг, дээд боловсрол олж авах боломж олгох эрдмийн зэргийн талаар үнэн зөв мэдээлэл түгээх болон авах нөхцөлийг хөнгөвчлөн дэмжинэ;

(c) Дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх асуудлаар, түүний дотор эрдмийн зэргийг үнэлэх шалгуур, журмын талаар болон эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх сайн туршлагатай холбоотой материалыг тухайн хууль тогтоомж, дүрэм журам, бодлогынхоо дагуу бэлтгэж бүрдүүлэх талаар зохих тохиолдолд зөвлөгөө, мэдээлэл өгнө;

(d) Дээд боловсролын тогтолцоонд нь хамаардаг боловсролын байгууллагаас олгосон эрдмийн зэргийн чанар нь хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээн авсан Оролцогч улсад хүлээн зөвшөөрөгдөх үндэслэлтэй эсэхийг тодорхойлох боломжийг бусад Оролцогч улсын эрх бүхий байгууллагад олгох зорилгоор аливаа тэдгээр байгууллага эсхүл тэдгээр байгууллагын хэрэгжүүлдэг аливаа хөтөлбөрийн талаар шаардлагатай мэдээллийг боломжит хугацаанд өгөх нөхцөлийг бүрдүүлнэ.

## IX зүйл. Өргөдлийг үнэлэх

1. Шаардлагатай мэдээлэл гаргаж өгөх үүрэг хариуцлага нь нэн тэргүүнд өргөдөл гаргагчийн үүрэг хариуцлага мөн бөгөөд өргөдөл гаргагч нь уг мэдээллийг үнэнч шударгаар бүрдүүлж өгнө.

2. Оролцогч улс бүр боловсролын тогтолцоонд нь хамаарах байгууллагууд нь эрдмийн зэрэг эзэмшигчид эсхүл хүлээн зөвшөөрөх хүсэлт хүлээн авсан Оролцогч улсын хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллагад холбогдох мэдээллийг боломжийн хэмжээнд, хүсэлтээр нь, боломжит хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргаж өгөх нөхцөлийг хангана.

3. Оролцогч улс бүр хүлээн зөвшөөрөх үнэлгээ хийж буй байгууллага нь өргөдөл шаардлага хангаагүй шалтгааныг эсхүл үлэмж ялгаа байгааг тодорхойлсоны үндэслэлийг гарган харуулж байх нөхцөлийг хангана.

Монгол Улсын Гадаад харилцааны Яам  
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН  
Гарын үсэг /Signature: *[Handwritten Signature]*  
2023 оны 01 сарын 10 өдөр  
Улаанбаатар хот  
Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

## **X зүйл. Хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллагын талаарх мэдээлэл**

1. Оролцогч улс бүр хүлээн зөвшөөрөх асуудлаар шийдвэр гаргадаг өөрийн харьяалалд буй эрх бүхий байгууллагын талаарх албан ёсны мэдэгдлийг энэхүү Конвенцын эх хадгалагчид хүргүүлнэ.
2. Оролцогч улсад хүлээн зөвшөөрөх эрх бүхий төв байгууллага байдаг бол тэдгээр нь энэхүү Конвенцын заалтыг нэн даруй дагаж мөрдөх бөгөөд тухайн Оролцогч улсын харьяаллын хүрээнд энэхүү Конвенцын заалтын хэрэгжилтийг хангахад шаардлагатай арга хэмжээг авна.
3. Хүлээн зөвшөөрөх асуудлаар шийдвэр гаргах эрх хэмжээг засаг захиргааны нэгжүүд нь эдэлдэг бол тухайн Оролцогч улс засаг захиргааны нөхцөл байдал болон бүтцийнхээ талаар энэхүү Конвенцод гарын үсэг зурах үедээ эсхүл соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан, нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулах үедээ, мөн түүнээс хойшхи аливаа өөрчлөлтийн талаар Конвенцын эх хадгалагчид товч мэдээлэл хүргүүлнэ. Ийм тохиолдолд засаг захиргааны нэгжийн ийнхүү томилогдсон хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллага нь Оролцогч улсын засаг захиргааны нөхцөл байдал болон бүтцийн хүрээнд боломжийн хэмжээнд энэхүү Конвенцын заалтын хэрэгжилтийг тухайн Оролцогч улсын харьяаллын хүрээнд хангахад шаардлагатай арга хэмжээг авна.
4. Хүлээн зөвшөөрөх асуудлаар шийдвэр гаргах эрх хэмжээг дээд боловсролын байгууллага эсхүл бусад байгууллага эдэлдэг бол Оролцогч улс бүр буюу тэдгээрийн засаг захиргааны нэгж нь засаг захиргааны нөхцөл байдал буюу бүтэцдээ нийцүүлэн энэхүү Конвенцын эх бичвэрийг тэдгээр байгууллагад хүргүүлж, Конвенцын заалтыг зохих ёсоор авч үзэн хэрэглэхийг хөхиүлэн дэмжих талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна.
5. Энэ зүйлийн 2, 3, 4 дэх хэсгийг энэхүү Конвенцын дагуу Оролцогч улсуудын хүлээсэн үүрэгт *mutatis mutandis* хэрэглэнэ.

## **XI зүйл. Дээд боловсролын хөтөлбөрт элсэхэд тавих нэмэлт шаардлага**

1. Дээд боловсролын тодорхой хөтөлбөрт элсэхэд элсэлтийн ерөнхий шаардлагаас гадна тодорхой нэмэлт шаардлага хангахыг шаарддаг бол тухайн Оролцогч улсын эрх бүхий байгууллага нь бусад Оролцогч улсад олж авсан эрдмийн зэрэг эзэмшигчдэд мөн адил тусгай нэмэлт шаардлагаа тавьж болно, эсхүл бусад Оролцогч улсад олж авсан эрдмийн зэрэг бүхий өргөдөл гаргагч нь мөн адил шаардлагыг хангаж буй эсэхийг үнэлж болно.
2. Хэрэв нэг Оролцогч улсад дээд боловсролын байгууллагад элсэх эрдмийн зэргийг олгохдоо ийнхүү элсэхийн тулд эрдмийн зэргийн нэмэлт шалгалт өгсөн байх шаардлага тавьдаг бол бусад Оролцогч улс дээрх шаардлагыг хангасны үндсэн дээр элсэлтийг хэрэгжүүлж болно, эсхүл өөрийн боловсролын тогтолцооны хүрээнд ийм нэмэлт шаардлагыг хангах өөр аргыг санал болгож болно.



3. IV зүйлийн заалтад харшлахгүйгээр, тухайн дээд боловсролын байгууллага буюу уг байгууллагын аль нэг хөтөлбөрт элсэх явц нь шударга, ил тод журмын дагуу хязгаарлагдмал эсхүл сонголтоор хэрэгждэг байж болно.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн тухайд элсэлтийн журам нь гадаад улсын эрдмийн зэргийн үнэлгээг III зүйлд заасан ил тод, шударга, алагчлалаас ангид байх зарчмын дагуу явуулах нөхцөлийг хангасан байна.

5. IV зүйлийн заалтад харшлахгүйгээр, тухайн дээд боловсролын байгууллагад элсэхийн тулд эрдмийн зэрэг эзэмшигч нь тухайн байгууллагын ашигладаг нэг буюу хэд хэдэн хэл эсхүл тусгайлан заасан өөр хэлний хангалттай чадвартай болохоо харуулсан байх нөхцөлийг тавьж болно.

6. Дээд боловсролын хөтөлбөрт элсүүлэх зорилгоор Оролцогч улс бүр өөрийн харьяалалд нь үйл ажиллагаа явуулдаг гадаадын боловсролын байгууллагаас олгосон эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөхдөө өөрийн буюу засаг захиргааны нэгжийн хууль тогтоомж, дүрэм журмын тодорхой шаардлагыг эсхүл тухайн боловсролын байгууллагыг үүсгэн байгуулсан Оролцогч улстай байгуулсан тодорхой хэлэлцээрийг хэрэгжүүлэх нөхцөлийг тавьж болно.

## ТАВДУГААР БҮЛЭГ. ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

### XII зүйл. Хэрэгжүүлэх бүтэц

Оролцогч улсууд энэхүү Конвенцыг дараах бүтцээр дамжуулан, мөн дараах бүтэцтэй хамтран ажиллаж хэрэгжүүлэхээр тохиролцов. Үүнд:

1. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтэц;
2. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтцийн сүлжээ;
3. Эрдмийн зэргийн магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалт, мэргэжлийн цар хүрээ, хүлээн зөвшөөрөх чиг үүрэгтэй үндэсний, бүс нутгийн, дэлхий дахины байгууллагууд;
4. Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хурал;
5. Хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцын хороод.

### XIII зүйл. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтэц

1. Дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх ажиллагааг хөнгөвчлөн дэмжих зорилгоор Оролцогч улсууд энэхүү Конвенцыг үндэсний мэдээллийн төв буюу ижил төстэй байгууллага зэрэг холбогдох байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

2. Оролцогч улс бүр үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтэц болон түүнд орсон өөрчлөлтийн талаар Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хурлыг Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.



3. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтэц нь сүлжээ үүсгэж, түүндээ идэвхтэй оролцох нь зүйтэй.

#### **XIV зүйл. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтцийн сүлжээ**

1. Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хурлын ивээл дор сүлжээд нь Оролцогч улсуудын үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтцээс бүрдэх бөгөөд энэхүү Конвенцыг бодит амьдралд хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлж, дэмжиж ажиллана.

2. Сүлжээд нь Оролцогч улсуудад хүсэлтийнх нь дагуу мэдээлэл солилцох, чадавхыг бэхжүүлэх, техникийн дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

3. Сүлжээд нь энэхүү Конвенцын хүрээнд бус нутаг хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхийг эрмэлзэж, Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хуралтай уялдаа холбоотой ажиллана.

4. Оролцогч улсууд нь хүлээн зөвшөөрөх тухай бус нутгийн конвенцоор байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй бус нутгийн сүлжээнд оролцож, эсхүл шинээр сүлжээ байгуулж болно. Бус нутгийн одоогийн сүлжээнд оролцохдоо тухайн бус нутгийн хүлээн зөвшөөрөх тухай конвенцын хорооны зөвшөөрлийг авна.

#### **XV зүйл. Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хурал**

1. Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хурал (цаашид "Бага хурал" гэх)-ыг байгуулна.

2. Бага хурал нь энэхүү Конвенцын Оролцогч бүх улсын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

3. Энэхүү Конвенцын Оролцогч бус улсуудыг болон хүлээн зөвшөөрөх тухай бус нутгийн конвенцын хороодын тэргүүнийг Бага хурлын хуралдаанд ажиглагчаар урьж оролцуулна.

4. Олон улсын болон бүсийн нутгийн холбогдох байгууллагын төлөөлөгчид, түүнчлэн дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх чиглэлээр ажилладаг засгийн газрын болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдийг Бага хурлын хуралдаанд ажиглагчаар урьж оролцуулж болно.

5. Бага хурал наад зах нь хоёр жил тутамд ээлжит хуралдаан зохион байгуулна. Ээлжит бус хуралдааныг Бага хурал тийнхүү шийдвэрлэснээр эсхүл Оролцогч улсуудын гуравны нэгээс доошгүй хувийн хүсэлтээр хийж болно. Бага хурал нь хуралдааны хооронд хэрэгжүүлдэг үйл ажиллагааны урьдчилсан хөтөлбөртэй байна. Бага хурал нь ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын ээлжит чуулган бүрт тайлан бэлтгэж хүргүүлнэ.

6. Бага хурал энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор анхдугаар хуралдаанаа хийх бөгөөд уг хуралдаанаар өөрийн дэгийн горимыг батална.



7. Бага хурал энэхүү Конвенцыг хэрэглэхийг хөхиүлэн дэмжиж, дэлхий дахины эсхүл бүс нутгийн түвшний зөвлөмж, тунхаглал, сайн туршлагын загвар, аливаа нэмэлт холбогдох баримт бичиг батлах замаар Конвенцын хэрэгжилтийг хянана.
8. Бага хурал хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцын хороодтой зөвлөлдсөний үндсэн дээр энэхүү Конвенцын Оролцогч улсуудад зориулан үйл ажиллагааны удирдамж баталж болно.
9. Энэхүү Конвенцын хэрэгжилттэй холбогдуулж ЮНЕСКО-гийн удирдах байгууллага хяналт шинжилгээ хийх, түүнд тайлагнахтай холбогдох үйл ажиллагааг Бага хурал дэмжинэ.
10. Бага хурал хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцын хороодтой ЮНЕСКО-гийн ивээл дор хамтран ажиллана.
11. Бага хурал болон хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцын хороод хоорондын шаардлагатай мэдээлэл солилцоог Бага хурал хангана.
12. Бага хурал XIII зүйлийн дагуу батлах энэхүү Конвенцод оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хянаж үзнэ. Батлагдсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү Конвенцод заасан ил тод, шударга, цаг үеэ олсон, алагчлалаас ангид байх зарчмыг бууруулж болохгүй.
13. Бага хурлын Нарийн бичгийн дарга нарын газрыг ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал хангана. Нарийн бичгийн дарга нарын газар нь Бага хурлын баримт бичгийг бэлтгэж, хуралдааны хэлэлцэх хэргийг боловсруулж, Бага хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангана.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

### XVI зүйл. Гишүүн улсууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах

1. ЮНЕСКО-гийн Гишүүн улсууд ба Гэгээн Ширээт Улс энэхүү Конвенцыг өөрсдийн үндсэн хуулийн ба хууль тогтоомжийн холбогдох журмын дагуу соёрхон батална эсхүл хүлээн зөвшөөрнө эсхүл батална.
2. Соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан тухай баримт бичгийг ЮНЕСКО-гийн Ерөнхий захиралд хадгалуулна.

### XVII зүйл. Нэгдэн орох

1. Энэхүү Конвенц нь ЮНЕСКО-гийн гишүүн улс биш боловч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гишүүн бүх улс нэгдэн ороход нээлттэй бөгөөд тэдгээрийг ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурал нэгдэн орохыг урьж байна.
2. Өөртөө засах бүрэн эрхтэй бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тийнхүү хүлээн зөвшөөрөгдсөн боловч Ерөнхий Ассамблейн 1514 (XV) дүгээр тогтоолын дагуу тусгаар тогтнолоо бүрэн олж аваагүй болон энэхүү Конвенцын зохицуулах



асуудлаар эрх хэмжээтэй (түүний дотор тэдгээр асуудлаар гэрээ байгуулах эрх хэмжээтэй) нутаг дэвсгэрүүд нэгдэн ороход энэхүү Конвенц мөн нээлттэй байна.

3. Конвенцод нэгдэн орсон тухай баримт бичгийг ЮНЕСКО-гийн Ерөнхий захиралд хадгалуулна.

### **XVIII. Хүчин төгөлдөр болох**

1. Энэхүү Конвенц нь конвенцыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай хорь дахь батламж жуух бичиг эсхүл баримт бичгийг хадгалуулсан өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болох бөгөөд гэхдээ энэ нь тухайн өдөр, эсхүл түүнээс өмнө соёрхон баталсан тухай холбогдох батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай холбогдох баримт бичгээ хадгалуулсан Оролцогч улсуудад хамаарна.

2. Бусад Оролцогч улсын хувьд тус Конвенцыг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш гурван сарын дараа энэхүү Конвенц хүчин төгөлдөр болно.

### **XIX зүйл. Конвенцын Оролцогч улсууд болон хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенц, бусад гэрээний талуудын хоорондын харилцаа**

1. Энэхүү Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн ороход хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн аливаа конвенцыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон байхыг шаардахгүй.

2. Энэхүү Конвенцын Оролцогч улсууд:

(a) Энэхүү Конвенц болон өөрийн нэгдэж орсон бусад гэрээ, ялангуяа хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенц хоорондын харилцан дэмжлэгийг хөхиүлэн дэмжинэ;

(b) Өөрийн нэгдэж орсон хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцыг тайлбарлах болон хэрэглэхдээ, эсхүл олон улсын бусад үүрэг хариуцлагыг хүлээхдээ энэхүү Конвенцын холбогдох заалтыг харгалзан үзнэ.

3. Энэхүү Конвенцын аль ч заалтыг Оролцогч улсын нэгдэж орсон хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенц болон аливаа бусад гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг нь өөрчилж буй хэмээн тайлбарлахгүй.

4. Энэхүү Конвенц, хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенц, хоёр талт буюу олон талт холбогдох аливаа бусад хэлэлцээр болон энэхүү Конвенцын Оролцогч улсын нэгдэж орсон байж болох эсхүл нэгдэж орж болох хүчин төгөлдөр үйлчилж байгаа буюу ирээдүйд хүчин төгөлдөр болох аливаа бусад гэрээ, конвенц хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор, эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой илүү тааламжтай заалт, ялангуяа үндэсний мэдээллийн төв, сүлжээ, үлэмж ялгааны тухай илүү тааламжтай заалтыг үгүйсгэж буй хэмээн энэхүү Конвенцын аль ч заалтыг үзэхгүй.

### **XX зүйл. Холбооны буюу нэгдмэл бус үндсэн хуулийн тогтолцоо**

Гарын үсэг /Signature:

*П. Сүхбаатар*

2023 оны 09 сарын 10 өдөр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION



Олон улсын хэлэлцээр нь Оролцогч улсуудын үндсэн хуулийн тогтолцооноос үл хамааран бүгдэд ижил тэгш заавал биелүүлэх хүчинтэйг хүлээн зөвшөөрөхийн хамт холбооны буюу нэгдмэл бус үндсэн хуулийн тогтолцоотой Оролцогч улсуудад дараах заалт үйлчилнэ. Үүнд:

(a) энэхүү Конвенцын заалтын хэрэгжилт хууль тогтоох холбооны эсхүл төв эрх мэдлийн эрх зүйн харьяалалд хамаарах тохиолдолд улс орнууд дахь болон холбооны эсхүл төв Засгийн газрын үүрэг нь холбооны бус Оролцогч улсуудынхтай ижил байна;

(b) энэхүү Конвенцын заалтын хэрэгжилт Оролцогч улсын засаг захиргааны нэгжүүд, тухайлбал, аймаг, муж, тойрог, дүүргийн эрх зүйн харьяалалд хамаарах бөгөөд тэдгээр засаг захиргааны нэгж нь холбооны үндсэн хуулийн тогтолцоо ёсоор хууль тогтоох арга хэмжээ авах үүрэггүй тохиолдолд холбооны Засгийн газар нь дээрх заалтын талаар Оролцогч улсын засаг захиргааны нэгжийн эрх бүхий байгууллагад шаардлагатай тохиолдолд мэдээлж, тэдгээрийг батлах зөвлөмжийг хамт хүргүүлнэ.

### XXI зүйл. Конвенцоос гарах

1. Энэхүү Конвенцын аливаа Оролцогч улс энэхүү Конвенцоос хэдийд ч гарч болно.
2. Конвенцоос гарах тухай мэдэгдлийг ЮНЕСКО-гийн Ерөнхий захиралд бичгээр хүргүүлж, хадгалуулна.
3. Конвенцоос гарах мэдэгдлийг хүлээн авснаас хойш 12 сарын дараа Конвенцоос гарах шийдвэр хүчин төгөлдөр болно. Энэ нь Конвенцоос гарах мэдэгдэл хүчин төгөлдөр болох өдөр хүртэл тус Конвенцоос гарсан Оролцогч улсын уг Конвенцын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагыг ямарваа байдлаар хөндөхгүй.
4. Энэхүү Конвенцоос гарах нь дараах зүйлд ямарваа нөлөө үзүүлэхгүй. Үүнд:

(a) Энэхүү Конвенцын заалтын дагуу өмнө гаргасан хүлээн зөвшөөрөх тухай шийдвэр;

(b) Энэхүү Конвенцын дагуу явцдаа байгаа хүлээн зөвшөөрөхтэй холбоотой үнэлгээ.

### XXII зүйл. Эх хадгалагчийн чиг үүрэг

Энэхүү Конвенцын эх хадгалагч болохын хувьд ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал нь дараах зүйлийн талаар ЮНЕСКО-гийн Гишүүн улсууд, XVII зүйлд заасан гишүүн бус улсууд болон Нэгдсэн Үндэстний Байгууллагад мэдээлнэ. Үүнд:

(a) XVI ба XVII зүйлд заасан соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай бүх батламж жуух бичиг буюу баримт бичгийг хадгалуулсан талаар;

(b) XXI зүйлд заасны дагуу Конвенцоос гарсан тухай;



(с) XXIII зүйлийн дагуу баталсан Конвенцод оруулсан нэмэлт өөрчлөлт болон XXIII зүйлд заасны дагуу нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болох өдрийн тухай.

### XXIII зүйл. Нэмэлт өөрчлөлт

1. Энэхүү Конвенцын аливаа Оролцогч улс Конвенцод нэмэлт өөрчлөлт оруулах саналаа ЮНЕСКО-гийн Ерөнхий захиралд бичгээр хүргүүлж болно. Ерөнхий захирал уг саналыг бүх Оролцогч улсад тараана. Хэрэв уг саналыг хүргүүлснээс хойш зургаан сарын дотор Конвенцын Оролцогч улсуудын тэн хагасаас доошгүй хувь уг саналыг дэмжсэн бол Ерөнхий захирал уг саналыг Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хурлын дараагийн хуралдаанд танилцуулан хэлэлцүүлж, батлах эсэхийг шийдвэрлүүлнэ.

2. Нэмэлт өөрчлөлтийг хуралд оролцож, саналаа өгсөн Оролцогч улсуудын гуравны хоёр хувийн саналаар батална.

3. Энэхүү Конвенцод оруулах нэмэлт өөрчлөлтийг баталсны дараа Оролцогч улсуудад соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох шийдвэр гаргуулахаар хүргүүлнэ.

4. Энэхүү Конвенцод орсон нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон Оролцогч улсуудын хувьд уг нэмэлт өөрчлөлт нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт тусгасан батламж жуух бичиг эсхүл баримт бичгийг Оролцогч улсуудын гуравны хоёр нь хадгалуулснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Түүнээс хойш, нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсхүл нэгдэн орсон Оролцогч улс бүрийн хувьд тухайн Оролцогч улс уг нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан өдрөөс хойш гурван сарын дараа уг нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн дагуу нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа Конвенцын Оролцогч улс болсон улс нь өөр санаатай байгаагаа илэрхийлээгүй бол тухайн улсыг:

(а) Нэмэлт өөрчлөлт орсон Конвенцын Оролцогч улс; бөгөөд

(б) Нэмэлт өөрчлөлтийг заавал дагаж мөрдөхгүй аливаа Оролцогч улстай холбогдуулж нэмэлт өөрчлөлт ороогүй Конвенцын Оролцогч улс

гэж тооцно.

### XXIV зүйл. Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлэх

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлд заасны дагуу энэхүү Конвенцыг ЮНЕСКО-гийн Ерөнхий захирлын хүсэлтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.



## XXV зүйл. Жинхэнэ эх бичвэр

Энэхүү Конвенцыг англи, араб, испани, орос, франц, хятад хэлээр боловсруулсан бөгөөд зургаан эх бичвэр бүгд адил хүчинтэй.

